000212

# БУЛГАН АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ....ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 04 өдөр Дугаар 05/07 Булган

Концессын зүйлийн жагсаалтад нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 3, "Концессийн тухай хууль"- ийн 4.1.3, 4.1.6, 6.1.2, 6.2.3, 10.2, 11.1, 17.2 -ыг үндэслэн Аймгийн ИТХ-ын V хуралдаанаас ТОГТООХ НЬ:

Нэг. "Орон нутгийн өмчийн концессийн зүйлийн жагсаалт"-д оруулах нэмэлтийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Жагсаалтад тусгагдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, хувийн хэвшлийн санал санаачлага, хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга /Д.Эрдэнэбат/-д зөвшөөрсүгэй.

Гурав.Жагсаалтад тусгагдсан төсөл арга хэмжээний концессийн гэрээг байгуулахдаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, гаргасан шийдвэрийн биелэлтийн явц, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг аймгийн ИТХ-д танилцуулахыг Хөгжлийн бодлогын хэлтэс /А.Ганболд/-т үүрэг болгосугай.

ДАРГА Д.БАТСАЙХАН

000213

Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны V хуралдааны 05/07-р тогтоолын хавсралт

## БУЛГАН АЙМГИЙН КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

| № | Концессынзүйлийннэр | Концессийн зүйлийн тодорхойлолт | Концессын төрөл | Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ | Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх баталгаа гаргах эсэх | Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх |
|---|---|---|---|---|---|---|
| | **Дэд бүтцийн салбарт** | | | | | |
| 1 | Булган дулааны станц | Булган сум | Барих – шилжүүлэх | Дулаан хангамжийн үйлчилгээ | Үгүй – судлаж шийдвэрлэх | Шууд гэрээ |

## БУЛГАН АЙМГИЙН КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ

| № | Концессын зүйлийн нэр | Концессийн зүйлийн тодорхойлолт | Концессын төрөл | Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ | Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх баталгаа гаргах эсэх | Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Соёл амралтын хүрээлэн | Аймгийн төвд соёл амралтын хүрээлэн байгуулах | Барих-шилжүүлэх | Барилга байгууламж, дэд бүтэц, тохижилтын ажил | Тийм | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 2 | Спорт усан бассейн барилга байгууламж | Булган аймгийн төвд орчин үеийн шийдэл бүхий усан спортын [illegible] | Барих – шилжүүлэх | Усан спорт хөгжих нөхцөл бүрдүүлнэ | Тийм | |

000214

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | сууцжуулах | | | | | |
| 4 | Аймгийн Театрийн барилга | Аймгийн төвд ТКХ-шинээр барьж байгуулах | Барих – шилжүүлэх | Барилга байгууламж, дэд бүтэц, тохижилтын ажил | | |
| 5 | Явган зам тавих | Сумдад | Барих – шилжүүлэх | Аймаг сумын төвийн хот тохижилт сайжирна | Тийм | |
| 6 | Авто зам барих | Булган сум | Барих – шилжүүлэх | Булган хотын доторхи зам тээвэр, дэд бүтэц сайжирна | Тийм | |
| 7 | Хангал, Баян- Агт сумдыг нэгдсэн халаалтад шилжүүлэх | Хангал, Баян – Агт сумдыг нэгдсэн халаалтын зуухны барилга, барьж, зуух, гадна шугам сүлжээ байгуулж албан байгууллагуудыг холбох | Зураг төсөв боловсруулах - барих – ашиглах шилжүүлэх | Халаалтын зуухны барилга байгууламж барих, инженерийн дэд бүтэц, шаардлагатай зам талбайг барих санхүүжүүлэх, дулаан үйлдвэрлэх, шилжүүлэх | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |
| 8 | Бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв, битүү зах барих | Бизнесийн жишигт нийцсэн худалдааны төвийн барилга, дэд бүтэц барьж байгуулах | Барих – ашиглах | Барилга байгууламж дэд бүтэц, тохижилтын ажил | Үгүй | Шууд гэрээ |
| 9 | Хүнсний аюулгүй байдлыг хангахуйц тээвэр агуулахын сүлжээ, ложисток байгуулах | Аймгийн төвд хүнсний бүтээгдэхүүний агуулахын худалдаа, тээвэр, ложисток үйлчилгээ явуулах барилга байгууламж, дэд бүтэц барьж байгуулах | Барих – ашиглах | Барилга байгууламж, дэд бүтэц, тохижилтын ажил | Үгүй | Шууд гэрээ |
| 10 | Сэлэнгэ сумын ЗДТГ-ыг нэгдсэн халаатын системд холбох | Сумын төвийн нэгдсэн халаалтын суурь тавигдсан | Барих – ашиглах шилжүүлэх | Дулааны шугам сүлжээ барьж, холбох ажил | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруулалт явуулах |